

АМЕРИГО ВЕСПУЧЧИЙН НЭРЭЭР НЭРЛЭГДСЭН ОРОН

*Л.БЭГЗЖАВ**

Америк тив, Америк улс бол Италийн далайчин Америго Веспуччийн нэрээр нэрлэгдсэн юм. Америк тивийн хамгийн анхны уугуул иргэд нь индианчууд бөгөөд тэдний өвөг дээдсийг Төв Азийн Монголчууд гэж үздэг. Төрлөх нутаг, гадаад ертөнцөөс таслагдсан индианчууд өөрсдийн өвөрмөц соёл, иргэншлийг бий болгож өнөөг хүрчээ. 1492 онд Христофр Колумб анх удаа Америк тивд хүрсэн боловч өөрөө “шинэ эх газар” нээснээ мэдсэнгүй дорнод энэтхэг гэж боджээ. Тэрбээр Испаний ванд бичсэн захидалдаа түүний олж мэдсэн газар нь Ази тивийн нэг хэсэг болохыг хэдэнтээ цохон тэмдэглэжээ.

АНУ-ын конгресс 1964 онд Х.Колумб Америкийг нээсэн хоёр дах хүн мөн гэж хүлээн зөвшөөрсөн юм. 1502 онд Флоренцийн далайчин Америго Веспуччи Колумбын явж өнгөрсөн замаар явж өмнөд Америкийн зүүн хойт хэсгийн эргийн дагуу нарийн хайгуул хийж барагцаалбал 25 түмэн жилийн өмнө монголчуудын өвөг дээдэс тэнгис далайг гатлан, Берингийн хоолойг туулж өнөөгийн Аляскийн баруун эргийн арлуудад амьдран сууж тарах болжээ. Хожим нь тэд эндээсээ өмнө зүг нүүдэллэн аажмаар Америк тивээр тархжээ гэж эрдэмтэд үздэг.¹

Колумбын нээсэн газар бол Ази тив биш, нэгэн шинэ эх газар юм гэсэн дүгнэлтийг Америго хийжээ. 1507 онд хэвлэгдсэн “сансар судлалын удиртгал” номын хавсралт зураг дээр энэхүү шинэ газрыг анх тойм байдлаар тэмдэглэж Веспуччийн нэрээр Америк гэж нэрлэжээ. Энэ нь Америкийн төн нээсэн газар гэсэн угтатай аж, энэ нэр чихэнд сонсголонтой, тогтооход хялбар нэр байсан тул хүмүүс түргэн хүлээн авчээ. Эхлээд энэ нэрийн хүрээ маш бага, зөвхөн Өмнөд Америкийн зүүн хойт хэсгээр л хязгаарлагдаж байв. 1538 онд хэвлэгдсэн дэлхийн газрын зургийн атласт бөмбөрцгийн баруун хагасын өргөн уудам эх газрыг бүхэлд нь Америк гэж тэмдэглэжээ. Нэрт зохиолч Стефан Цвейг “Америго” гэдэг номондоо “Аливаа нээлт, аливаа бүтээл нь хэн түүнийг нээсэн буюу бүтээснээр төдийгүй харин хэн түүний жинхэнэ ач холбогдол, үйлчлэх хүчийг илрүүлснээр улам ч үнэ цэнэтэй болдог бөгөөд Колумб шинэ тив нээж гавьяа байгуулсан бол Веспуччи тийнхүү

* Л.Бэгзжав - Ph.D. дэд профессор

шинэ тив нээснийг нь ухаарч, учрыг таниулсанаар түүхэн гавьяа байгуулсан юм. Ийм бага юм бичсэн хүн тэгж их алдаршиж байсан удаа хэзээ ч байхгүй гэж хэлэхэд хэтрүүлсэн хэрэг болохгүй санамсаргүй явдал дараа дараагаар давхцаж, алдаа дараа дараагаар гарсанаар ганцхан тэр бүтээл нь эзнээ эрин зууны тэргүүнд гарсан алдар нэрийг нь өнөө үе хүртэл мөнхжүүлсэн юм гэж шударгаар тэмдэглэсэн байдаг.

Америк тив асар өргөн удам учраас хожим хүмүүс Панамын сувгийн зүүн эргээр хил болгож өмнөд, умарт Америк тив гэж хуваажээ. Дараа нь Хойт Америк мөн өмнөд хэсгийг буюу Мексикээс Панам хүртэл, баруун Энэтхэгийн бүлэг орныг оролцуулан Төв Америк буюу Латин Америк гэх болжээ. Энэ нутугт Латин хэлт үндэстэнүүд олон байдгаас ийн нэрийджээ.

XVIII зуунаас өмнө Англи улс Умарт Америкийн Атлантын далайн эрэгт 13 колонийн газар байгуулсан бөгөөд 1775 онд эдгээр колонийн газрын ард түмэн Английн колончлогчдын эсрэг тусгаар тогтнолын дайн хийж 1776 оны 7-р сарын 4-нд колончлолын ард түмэн тусгаар тогтнолоо зарлаж АНУ байгуулагдсаныг тунхаглав. Америк улс байгуулахдаа өөрсдийгөө Америк тивд голлогч байр суурьтай гэж үзэж байсан учраас Америк тивийн нэрийг улсынхаа нэр болгожээ. 1787 онд АНУ-ын Үндсэн хуулинд албан ёсоор the United States of America /USA/ гэж тэмдэглэжээ.² Америкийн хоч нэр нь Сэм Авга "Uncle Sam" гэдэг. 1812 оны Америк Английн дайны үед америк цэргийн хэрэгцээнд үхрийн мах нийлүүлдэг Смаул Вильсон гэдэг худалдаачин байжээ. Түүнийг хүмүүс Сэм авга буюу Uncle Sam буюу товчоор US гэж дууддаг байв. Америк улсын нэрийг англиар US гэж товчилдогтой адил юм. Америкийн засгийн газар худалдаж авсан үхрийн махны хайрцагны таган дээр US гэж бичдэг байсан нь АНУ-ын засгийн газрын өмч гэсэн утга илэрхийлдэг байжээ.

Хүмүүс тоглоом болгож US гэсэн бичигтэй хайрцагуудыг бүгдээрээ Сэм авгынх гэдэг байжээ. Хожим нь "Сэм авга" гэдэг нь Америкийн хоч нэр болсон юм. XIX зууны 30-аад онд Америкийн нэг шог зураач Сэм авгын зургийг буурал толгойтой ямаан сахал тавьсан, 5 хошуу одтой өндөр бүрх малгай өмссөн өндөр туранхай өвгөнөөр зуржээ. 1961 онд Америкийн сенат Сэм авга бол Америкийн билиг тэмдэг мөн гэж хүлээн зөвшөөрчээ.³

АНУ нь 9364 мянган км² газар нутагтай Орос, Канад, Хятадын дараа дэлхийд 4-рт ордог. Хүн амын тоогоор дэлхийд 3-рт буюу 263 сая хүн амтай, 1 км² газарт 28 хүн ногддог.⁴ Америк бол нүүдэллэн

суурьшигчдын буюу цагаачдын улс бөгөөд үндсэн оршин суугч 100 гаруй үндэстнээс бүрдэнэ. Цагаан арьстан хүн амын 84.1 хувь, хар арьстан 12 хувь, ази гаралтай хүн 2 хувь / хятал цагаач 1 саяас илүү/ хүн амын 63 хувь нь шашин шүтдэг. Одоогийн америкчуудын 94% нь АНУ-д төржээ.⁵ Америкт 253 шашны урсгал байдгаас христос, каталог, морман, жүдийн шашин, будда зэрэг болно.

Бүгд найрамдах нам, ардчилсан нам гэсэн гол 2 намтай. БНН-ын билэгдэл нь заан, Ардчилсан намын билэгдэл нь илжиг. Төрийн шувуу нь цагаан толгойтой халцгай бүргэд бөгөөд эр зориг, хүч чадал, ялалтыг билэгддэг. Халцгай бүргэд нь Америкт байдаг нэгэн төрлийн асар том, далайн бүргэд бөгөөд гадаад үзэмж нь гоёмсог, догшин дүртэй, нийтдээ 5000 орчим байдаг байна.

Гоё сайхан, анхилам үнэрт сарнай цэцгийг халуун сэтгэл, хайр дурлалын билэгдэл болгож төрийн цэцэг гэж дээдэлдэг.

Төрийн далбаа нь 5 хошуу одтой, 7 улаан, 6 цагаан нийт 13 хөндлөн зурвастай. Зүүн дээд буланд нь хөх өнгөтэй гонзгой дөрвөлжин дэвсгэр дээр 50 ширхэг цагаан 5 хошууг 9 эгнээ хувааж байрлуулсан. 13 өргөн зураас нь анхны 13 мужийг, 50 таван хошуу од нь одоогийн 50 муж улсыг билэгддэг, улаан өнгө нь хүч зоригтойн, цагаан нь цэвэр ариун, хөх нь сонор сэрэмжтэй, эрс хатуу, нугаршгүй шударгыг билэгддэг. Төрийн тамга ба сүлд нь дундаа хоёр жигүүрээ дэлгэн баруун савартаа чидун жимсний мод, зүүндээ 13 хурц сум атгасан бүргэдийн дүртэй байдаг. Төрийн дуулал нь "Одон хуарт далбаа" нэртэй, улсын сургаал үг нь in God We-Trust-бурханд бид итгэдэг.

Улсын гол баяр нь тусгаар тогтнолын өдөр буюу 7-р сарын 4-нд байдаг. Зэвсэгт хүчний баярыг 5-р сарын 17-нд тэмдэглэдэг. Агаарын цэргийн баярыг 9 -р сарын хоёр дахь бямба гаригт тэмдэглэдэг. Индианчууд бол Америкийн уугуул иргэд юм. Х. Колумбо анх Америкийг нээж, дорнод Энэтхэг байна гэж бодохдоо шар үстэй, босоо үстэй, хар нүдтэй, зүүн азийн зарим орны хүмүүстэй адилхан нутгийн оршин суугчдыг хараад энэтхэгчүүдээс ялгах гэж индиан гэж нэрлэжээ. Америкт одоо 1 360 000 индианчууд байна гэлгээдэг. ХҮ зууны эцсээр индианчуудын тоо сая гаруй байсан гэсэн тооцоо байдаг хожим европын колончлогчдын гарт олон зуугаараа хэлмэгдэн урьд өмнө байгаагүй олноор хорогджээ. 1890 оны хүн амын тооллогоор индианчууд дөнгөж 248 000 үлдсэн байсан ба индианчуудыг хамгаалах бүс байгуулсанаар тэдний амьдралын нөхцөл сайжирч аажимаар өсчээ. Түүхийн элдэв нугалаа үзсэн индианчууд АНУ-ын олон муж хотоор

тархан суусанаас гадна ерөөс Америк тивийн олон арван газар оршин аж төрсөөр байна. Индианчуудын үүсэл гарал, аж төрөх ёс, хэл соёл иргэншлийг нарийвчлан судлах нь өнөөгийн америк судлалын салшгүй нэг хэсэг байх учиртай.

Ишлэл

1. Жунго Жоувянь гожя гайкуан Бээжин 1994 18-р тал
Г. Пивоварова Сонирхолтой газар зүй М., 1988 /монгол хэлээр/
13-р тал
2. Америкийн нэгдсэн улсын үндсэн хууль. УБ. 2000
3. Shi jie geguo guoming jijin Бээжин 1987, 150-151-р тал
4. Нихон кокусей зүд 55 дахь хэвлэл 1997/1998, 43-р тал
Дуглас К.Стивенсон. Америкийн нийгэм амьдрал заншил. УБ.
1996. 15-р тал